



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2021 оны 04 сарын 02 одор

Дугаар А/135

Улаанбаатар хот

Г Түр журам шинэчлэн батлах тухай Г

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийг үндэслэн Коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8, 7.1.9 дэх заалтыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. “Өмчийн хэлбэр харгалзахгүй бүх шатны боловсролын сургалтын байгууллага нь суралцагчийн сургалтын төлбөрт хөнгөлөлт үзүүлэх, дараагийн төлбөрт шилжүүлэх түр журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Түр журмын хэрэгжилтийг арга зүйн удирдлагаар хангаж, сар бүр тогтмол мэдээлж ажиллахыг Дээд боловсролын газар /Г.Батнэмэх/, Бага, дунд боловсролын газар /Т.Ням-Очир/, Сургуулийн өмнөх боловсролын газар /Ж.Мягмар/-т тус тус даалгасугай.
3. Түр журмын хэрэгжилтийг зохион байгуулж, багш, ажилтан, суралцагч, оюутанд хэрэгжилтийн талаарх тодорхой мэдээллийг сар тутам өгч, шуурхай ажиллахыг Аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга, өмчийн хэлбэр харгалзахгүй бүх шатны боловсролын сургалтын байгууллагын захирал, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.
4. Сургалтын төлбөрийг уян хатан нөхцөлөөр сар, улирлаар тооцон авах, сургалтын төлбөр төлөгдөөгүйн улмаас цахим болон танхимиын хэлбэрээр хичээл сургалтад хамрагдахыг хязгаарлахгүй байхыг ерөнхий боловсролын сургуулийн захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.
5. Их, дээд сургууль, коллежийн оюутнаас урьдчилсан төлбөр төлөх шаардлага тавихгүй, анги дэвших болон төгсөлтийн шалгалт, диплом хамгаалалт, хичээл сонголтыг цуцлахгүй байх зохицуулалт хийхийг Их, дээд сургууль, коллежийн захирал нарт даалгасугай.

142110502


6. Төлө, цахим сургалтын агуулга, чанарт тогтмол үнэлгээ хийн, тасралтгүй сайжруулалт хийж ажиллахыг Боловсролын хүрээлэн /П.Лхагвасүрэн/-д үүрэг болгосугай.

7. Багш нарын чадварыг сайжруулах, дэмжих, цахим хичээл бэлтгэх, заах орчин нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авч ажиллахыг бүх шатны боловсролын сургалтын байгууллагын захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

8. Энэхүү түр журмын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг сар бүр нэгтгэн төрийн захиргааны төв байгууллагад дараа сарын 5-ны өдрийн дотор багтаан ирүүлж байхыг Аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга, Боловсролын хүрээлэн, Их, дээд сургууль, коллежийн захирал нарт тус тус үүрэг болгосугай.

9. Түр журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Батбаатар/-т даалгасугай.

10. Энэхүү түр журам шинэчлэн батлагдсантай холбоотойгоор Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/11 дүгээр тушаалаар батлагдсан “Өмчийн хэлбэр харгалзахгүй бүх шатны боловсролын байгууллага суралцагчийн сургалтын төлбөрт хөнгөлөлт үзүүлэх, дараагийн төлбөрт шилжүүлэх түр журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.



Боловсрол, шинжлэх ухааны сайдын
2021 оны 09 дүгээр сарын 02-ны
өдрийн тушаалтын хавсралт

ӨМЧИЙН ХЭЛБЭР ХАРГАЛЗАХГҮЙ БҮХ ШАТНЫ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН
БАЙГУУЛЛАГА НЬ СУРАЛЦАГЧИЙН СУРГАЛТЫН ТӨЛБӨРТ ХӨНГӨЛӨЛТ
ҮЗҮҮЛЭХ, ДАРААГИЙН ТӨЛБӨРТ ШИЛЖҮҮЛЭХ ТҮР ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү түр журмаар Коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль хэрэгжих хугацаанд өмчийн хэлбэр харгалзахгүй бүх шатны боловсролын сургалтын байгууллага нь суралцагчийн сургалтын төлбөрт хөнгөлөлт үзүүлэх, дараагийн төлбөрт шилжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Түр журмын зорилго нь суралцагчийн тасралтгүй, чанартай боловсрол эзэмших нөхцөл боломжийг бүрдүүлэх, цахим сургалтын чанар, хүртээмжийг сайжруулахад оршино.

1.3. Сургалтын төлбөрийн хөнгөлөлт эдлэх, дараагийн улиралд шилжүүлэн тооцох талаар цэцэрлэг, сургуулийн дотоодод мөрддөг баримт бичигт тусган, суралцагчийн эцэг, эх, асран хамгаалагч /цаашид эцэг эх гэх/, оюутантай зөвшилцэж, тэдэнтэй байгуулсан гэрээгээр баталгаажуулна.

1.4. Төлбөртэй үйл ажиллагаа явуулдаг бүх шатны сургалтын байгууллага нь сургалтын төлбөрийн бүтэц, бүрдүүлэлт, зарцуулалтын талаар эцэг эх, оюутанд мэдээлэл өгч хэвших үүрэг хүлээнэ.

1.5 Цар тахлын хорио цээр, хязгаарлалтын үед төрөөс үзүүлж буй эрчим хүч, нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөрийн хөнгөлөлт, хувьсах зардлын санхүүжилт авч байгаа төрийн бус өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль нь зайны сургалт /теле, цахим/-ыг зохион байгуулах хугацаандаа 2019-2020 оны хичээлийн жилд тогтоосон сургалтын төлбөрийн дүнтэй харьцуулж, суралцагч бүрд сургалтын төлбөрийн 5-аас доошгүй хувийн хөнгөлөлт үзүүлнэ.

1.6 Цар тахлын хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед төрийн бус өмчийн цэцэрлэг, сургуулийн хувьсах зардлыг олгохдоо суралцагчийн сургалтын төлбөрт хөнгөлөлт үзүүлсэн байдал, төле хичээл болон цахим сургалтад хамрагдсан ирцийн гүйцэтгэл, сургалтын үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулсан тайланд үндэслэн олгоно.

1.7 Цар тахлын хорио цээр, хязгаарлалтын үед 10.0 сая төгрөгөөс дээш сургалтын төлбөр бүхий ерөнхий боловсролын сургуульд төрөөс нэг суралцагчид ноогдох хувьсах зардлын дундаж нормативаар санхүүжилтийг олгохгүй.

Хоёр. Сургалтын төлбөрийг хөнгөлөх

2.1. Сургуулийн өмнөх боловсролын байгууллага дараах зохицуулалт хийнэ:

2.1.1. Төлбөртэй үйл ажиллагаа явуулдаг цэцэрлэг нь төлбөрийг эцэг, эхийн санхүүгийн нөхцөл боломжид суурилан уян хатан нөхцөлөөр сар, улирлаар тооцон авах;

2.1.2. Эцэг, эхийн хөдөлмөр эрхлэлт, өрхийн орлогын байдлыг харгалзан төлбөрийн хөнгөлөлтийг зөвшилцэн, тодорхой хөнгөлөлт үзүүлэх;

2.1.3 Цэцэрлэгт хүүхдээ үргэлжлүүлэн явуулах боломжгүй болсон эцэг, эхэд төлсөн төлбөрийн үлдэгдэл хэсгийг буцаан олгох.

2.2. Ерөнхий боловсролын байгууллага дараах зохицуулалт хийнэ:

2.2.1. Төлбөртэй үйл ажиллагаа явуулдаг ерөнхий боловсролын сургууль нь сургалтын төлбөрийг эцэг, эхийн санхүүгийн нөхцөл боломжид суурилан уян хатан нөхцөлөөр сар, улирлаар тооцон авах;

2.2.2. Теле хичээлээс гадна суралцагчид цахим хичээл, давтлага өгсөн тохиолдолд түүнд зарцуулагдсан зардлын тооцоо нь төлбөртэй хэрхэн уялддаг талаар эцэг, эхэд тодорхой мэдээлж, дээрх зорилгоор дахин нэмэлт төлбөр авахгүй байх;

2.2.3. Эцэг, эхтэй төлбөрийн хөнгөлөлтийн асуудлаар тэдний хөдөлмөр эрхлэлт, орлогын байдлыг харгалзан зөвшилцэж, тодорхой хөнгөлөлт үзүүлэх;

2.2.4. Сургалтын төлбөр төлөгдөөгүйн улмаас цахим болон танхимын хэлбэрээр хичээл сургалтад хамрагдахыг аливаа хэлбэрээр хязгаарлахгүй байх;

2.2.5. Сургуульд хүүхдээ үргэлжлүүлэн явуулах боломжгүй болсон эцэг, эхэд төлсөн сургалтын төлбөрийн үлдэгдэл хэсгийг буцаан олгох;

2.3. Дээд боловсролын байгууллага дараах зохицуулалт хийнэ:

2.3.1. Төлбөртэй үйл ажиллагаа явуулдаг их, дээд сургууль, коллеж нь сургалтын төлбөрийг оюутны гэр бүлийн санхүүгийн боломжид суурилан уян хатан нөхцөлөөр хэсэгчлэн, тодорхой хугацаа тохиролцон авах;

2.3.2. Оюутны цахим хичээлд хамрагдсан ирц, идэвхи, чадвар, явцын дүн зэргийг харгалзан олон төрөлт хэлбэрээр сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх;

2.3.3 Оюутанд нэрэмжит тэтгэлэг, сургалтын тэтгэлэг, тусlamж олгох асуудлыг сургуульд мөрддөг холбогдох журмын дагуу нэмэгдүүлэх, идэвхжүүлэх;

2.3.4 Сургуулийн дотуур байранд амьдардаг оюутны байрны зардлын зөрүү болон илүү төлөлтийг оюутантай тохиролцон буцаан олгох, өөр төлбөрт шилжүүлэх, эсхүл дараагийн улирлын төлбөрт шилжүүлэн тооцох.

Гурав. Сургалтын төлбөрийг дараагийн улиралд шилжүүлэх

3.1. Тухайн улиралд хүндэтгэх шалтгаанаар судалж чадаагүй хөтөлбөр, хичээлийг оюутны хүсэлтээр цуцлан, дараагийн улиралд судлах боломж олгон төлбөрийг шилжүүлнэ.

3.2. Суралцагч, оюутан нь цахим хичээлийн чанар, хүртээмжийн хангалтгүй байдлаас хамаарч хичээл, хөтөлбөрийг дахин нэмэлтээр судлах хүсэлт гаргасан тохиолдолд үндэслэлийг судлан, тухайн хичээлээр дахин төлбөр авахгүй байх, тодорхой төлбөрийг шилжүүлэх арга хэмжээ авна.